



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР СУМЫН 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/62/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас: 88011833 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 6 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.МӨНХЗУЛ ТАНАА 7

2021.02.25 № 2/64

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ 7

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

2021 A4 TOOT

• 005021023

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,003,745.82	82,760,646.61
35	БАРАА МАТЕРИАЛ	73,003,745.82	82,760,646.61
351	Түүхий эд материал	7,093,723.52	8,334,533.52
35110	Тусгай зориулалттай материал	7,045,583.52	7,989,583.52
35130	Эм боох материал	48,140.00	344,950.00
354	Хангамжийн материал	65,910,022.30	74,426,113.09
35410	Бичиг хэргийн материал	3,299,584.00	3,698,144.00
35420	Аж ахуйн материал	46,782,321.51	51,875,164.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	66,000.00
35450	Барилгын засварын материал	325,000.00	2,615,300.00
35460	Хүнсний материал	2,202,866.80	1,381,255.10
35470	Бусад хангамжийн материал	13,300,249.99	14,790,249.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,551,492,685.31	1,516,225,160.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,551,492,685.31	1,516,225,160.67
392	Биет хөрөнгө	1,500,864,109.17	1,465,701,966.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,450,483,205.58	1,450,483,205.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,056,743.96	-51,853,955.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,845,670.00	67,413,693.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,734,485.19	-24,017,247.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,930,427.46	42,630,427.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,603,964.72	-18,954,156.36
393	Биет бус хөрөнгө	50,628,576.14	50,523,194.47
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-556,423.86	-661,805.53
39303	Бусад биет бус хөрөнгө	50,460,000.00	50,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,624,496,431.13	1,598,985,807.28
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,624,496,431.13	1,598,985,807.28
51	Засгийн газрын хувь оролцоо	1,624,496,431.13	1,598,985,807.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,218,577.00	164,218,577.00
51101	Өмч: - төрийн	164,218,577.00	164,218,577.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,140,196,761.68	1,114,686,137.83
51210	Өмнөх үеийн үр дүн	1,140,196,761.68	1,140,196,761.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-25,510,623.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	320,081,092.45	320,081,092.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,624,496,431.13	1,598,985,807.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,636,486,829.59	536,328,323.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,146,518,629.59	8,601,523.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,146,518,629.59	8,601,523.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,146,518,629.59	8,601,523.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,146,518,629.59	8,601,523.00

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	489,968,200.00	527,726,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	440,704,200.00	442,847,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	440,704,200.00	442,847,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,797,600.00	13,646,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,350,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,447,600.00	13,646,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,466,400.00	71,233,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,466,400.00	71,233,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	499,865,751.77	561,838,946.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	499,865,751.77	561,838,946.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,007,343.77	535,433,937.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,037,988.00	334,309,733.08
210101	Үндсэн цалин	293,037,988.00	270,363,233.08
210102	Нэмэгдэл	00.00	40,699,300.00
210104	Урамшуулал	00.00	23,247,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,980,504.00	42,020,900.00
210201	Тэтгэврийн даатгал	25,704,774.00	28,574,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,874,042.00	3,361,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,299,235.00	2,689,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	554,769.00	672,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,547,684.00	6,723,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,726,400.00	66,872,908.69
210301	Гэрэл, цахилгаан	4,780,167.00	3,114,672.93
210302	Түлш, халаалт	25,756,180.00	54,209,516.76
210303	Цэвэр, бохир ус	8,190,053.00	9,548,719.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,720,259.04	6,549,747.51
210401	Бичиг хэрэг	775,920.00	1,088,640.00
210402	Тээвэр, шатахуун	280,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,108,865.00	1,411,400.00
210404	Ном, хэвлэл	00.00	52,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	180,000.00	1,926,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,471,604.16	1,470,007.51
210408	Бараа материал акалсны зардал	2,903,869.88	00.00
2105	Норматив зардал	78,460,693.20	33,855,100.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,660.00	736,590.00
210502	Хоол, хүнс	78,404,033.20	33,118,510.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,027,450.00	33,000.00
210604	Урсгал засвар	13,027,450.00	33,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,796,800.00	168,000.00
210701	Гадаад албан томилолт	1,600,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	196,800.00	168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,175,850.00	1,046,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,175,850.00	777,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	269,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,081,399.53	50,577,647.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	305,500.00	1,042,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,775,899.53	49,535,547.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,858,408.00	26,405,009.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,858,400.00	14,356,800.00

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,447,600.00	13,646,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,800.00	710,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,594,291.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,594,291.31
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	08.00	8,453,917.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	08.00	8,453,917.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,136,621,077.82	-25,510,623.85
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	74,999.92	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	74,999.92	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-74,999.92	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,136,546,077.90	-25,510,623.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	489,968,200.00	527,726,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	489,968,200.00	527,726,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	440,704,200.00	442,847,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,797,600.00	13,646,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,350,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,447,600.00	13,646,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,466,400.00	71,233,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,466,400.00	71,233,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	489,968,200.00	520,920,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,968,200.00	520,920,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,109,792.00	494,515,290.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,682,892.00	334,309,733.08
210101	Үндсэн цалин	245,323,092.00	270,363,233.08
210102	Нэмэгдэл	25,834,600.00	40,699,300.00
210104	Урамшуулал	21,525,200.00	23,247,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,335,600.00	42,020,900.00
210201	Тэтгэврийн даатгал	25,868,700.00	28,574,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,866,800.00	3,361,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,293,300.00	2,689,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	599,500.00	672,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,707,300.00	6,723,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,666,400.00	66,638,908.69
210301	Гэрэл, цахилгаан	4,780,167.00	3,114,672.93
210302	Түлш, халаалт	25,696,180.00	53,975,516.76
210303	Цэвэр, бохир ус	8,190,053.00	9,548,719.00

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	4,757,200.00	7,211,750.00
210401	Бичиг хэрэг	323,100.00	486,500.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,108,865.00	1,411,400.00
210404	Ном, хэвлэл	105,400.00	245,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	1,926,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,699,835.00	2,241,550.00
2105	Норматив зардал	85,106,600.00	37,355,599.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	94,300.00	2,598,400.00
210502	Хоол, хүнс	79,167,000.00	32,296,899.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,845,300.00	2,460,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,304,700.00	3,323,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,378,200.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	15,926,500.00	2,323,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,796,800.00	168,000.00
210701	Гадаад албан томилолт	1,600,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	196,800.00	168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,680,900.00	1,046,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,430,900.00	777,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	269,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,778,700.00	2,440,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,778,700.00	2,440,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,858,408.00	26,405,009.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,858,400.00	14,356,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,447,600.00	13,646,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,800.00	710,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,594,291.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,594,291.31
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	08.00	8,453,917.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	08.00	8,453,917.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	6,806,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	6,806,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	6,806,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	6,806,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	6,806,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-6,806,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	13,646,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	13,646,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	13646000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	13,646,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	13,646,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	13646000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	13646000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,646,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /			
		Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	514,080,800.00	502,032,590.77	12,048,209.23	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,080,800.00	502,032,590.77	12,048,209.23	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	513,370,000.00	501,321,790.77	12,048,209.23	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,166,900.00	334,309,733.08	1,857,166.92	99.4
210101	Үндсэн цалин	272,220,400.00	270,363,233.08	1,857,166.92	99.3
210102	Нэмэгдэл	40,699,300.00	40,699,300.00	0.00	100.0
210104	Урамшуулал	23,247,200.00	23,247,200.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ш	42,020,900.00	42,020,900.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	28,574,200.00	28,574,200.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,361,700.00	3,361,700.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,689,400.00	2,689,400.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	672,300.00	672,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,723,300.00	6,723,300.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,233,200.00	66,638,908.69	3,594,291.31	94.9
210301	Гэрэл, шахилгаан	3,799,200.00	3,114,672.93	684,527.07	82.0
210302	Тулш, халаалт	55,962,000.00	53,975,516.76	1,986,483.24	96.5
210303	Цэвэр, бохир ус	10,472,000.00	9,548,719.00	923,281.00	91.2
2104	Хангамж, бараа материалын зардал	7,280,200.00	7,211,750.00	68,450.00	99.1
210401	Бичиг хэрэг	489,800.00	486,500.00	3,300.00	99.3
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	900,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,411,400.00	1,411,400.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	245,400.00	245,400.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	1,992,000.00	1,926,900.00	65,100.00	96.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,241,600.00	2,241,550.00	50.00	100.0
2105	Нормативт зардал	40,056,100.00	40,055,599.00	501.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,598,400.00	2,598,400.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	32,297,400.00	32,296,899.00	501.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,160,300.00	5,160,300.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,791,300.00	3,323,300.00	6,468,000.00	33.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,468,000.00	1,000,000.00	6,468,000.00	13.4
210604	Урсгал засвар	2,323,300.00	2,323,300.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	196,800.00	168,000.00	28,800.00	85.4
210702	Догоод албан томилолт	196,800.00	168,000.00	28,800.00	85.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний т	1,077,900.00	1,046,900.00	31,000.00	97.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил ү	777,900.00	777,900.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	269,000.00	31,000.00	89.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6546700.00	6546700.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,546,700.00	6,546,700.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	710800.00	710800.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	710,800.00	710,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	710,800.00	710,800.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	514,080,800.00	502,032,590.77	12,048,209.23	97.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	442,847,600.00	434,393,682.08	8,453,917.92	98.1
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,847,600.00	434,393,682.08	8,453,917.92	98.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,233,200.00	67,638,908.69	3,594,291.31	95.0
132001	Орон нутгийн төсвөөс	71,233,200.00	67,638,908.69	3,594,291.31	95.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32	00	100.0
620001	Удирдах ажилтан	01	01	00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13	13	00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖАА	280	280	00	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН Б.	280	280	00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	280	280	00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансн	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,646,000.00	13,646,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,646,000.00	13,646,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13646000.00	13646000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,646,000.00	13,646,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13646000.00	13,646,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13646000.00	13646000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13646000.00	13646000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13646000.00	13,646,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Д.Мөнхзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2021 оны 02 дугаар сарын 22-ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 96 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалтай сургалт хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 561838,9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11236,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1598985.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 25510.6 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,003.7	82,760.6	9,756.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	73,003.7	82,760.6	9,756.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,551,492.7	1,516,225.2	(35,267.5)
Үндсэн хөрөнгө	1,597,444.3	1,611,712.3	14,268.0
Хуримтлагдсан элэгдэл	(45,951.6)	(95,487.2)	(49,535.5)
Нийт хөрөнгө	1,624,496.4	1,598,985.8	(25,510.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,624,496.4	1,598,985.8	(25,510.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,624,496.4	1,598,985.8	(25,510.6)

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 82760,6 мянган төгрөг болж 9756,0 мянган төгрөгөөр өссөн нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас 240,0 мянга, хандиваар авсан 900,0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 2323,3 мянган төгрөгийн барилгын засварын материалыг агуулахын дээвэр засварлахаар, хүнсний материалын дансанд 1381,2 мянга, аж ахуй дансанд 5092,8 мянган төгрөгийг материалын үлдэгдлээс шалтгаалж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1611712,3 мянган төгрөг болж 14268,0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6806,5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 7461,5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 7461,5 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, урсгал төсвийн санхүүжилтээр худалдан авсан 6806,2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1598985.8 мянган төгрөг болж 25510.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 25510.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 536328.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 1100158.5 мянган төгрөгөөр буюу 67.2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 1137917.1 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос буурсантай, тусламж санхүүжилтийн орлого 37758.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 2143.4 мянга, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 29766.8 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан орлого 5848.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 561838.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 61973.2 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг нэмэгдэж, норматив зардал, эд хогшил урсгал засварын зардал буурсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 727227,8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 727227,8 мянган төгрөгөөр тооцон ажиллагсдын тоо 33 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 121036,2 мянган төгрөгөөр бууруулж 606191,6 мянган төгрөгөөр орон тоог 32 –оор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 606191,6 мянган төсөв батлагдаж 3 удаа тодотгол хийн 514080.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 442847.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 71233.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 71233.2 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 442847.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 502032.6 мянган төгрөгийг зарцуулж 12048.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 502032.6 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 1857.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 3594.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 68.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 6468.0 мянга, томилолт зочны зардлыг 28.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний зардлыг 31.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 80109 арга хэмжээ 3594.3 мянга, 81834 арга хэмжээ 3717.3 мянга, 81835 арга хэмжээ 12170.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт -2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөр арга хэмжээгээр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	514,080,800.00	502,032,590.79	12,048,209.21	97.66
АРГА ХЭМЖЭЭ 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	71,233,200.00	67,638,908.69	3,594,291.31	94.95
УРСГАЛ ЗАРДАЛ	71,233,200.00	67,638,908.69	3,594,291.31	94.95
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,233,200.00	67,638,908.69	3,594,291.31	94.95
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,233,200.00	66,638,908.69	3,594,291.31	94.88
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	
ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	32,297,400.00	32,296,899.00	501.00	
АРГА ХЭМЖЭЭ 81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	32,297,400.00	32,296,899.00	501.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,297,400.00	32,296,899.00	501.00	100.00
Нормативт зардал	32,297,400.00	32,296,899.00	501.00	100.00
ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	710,800.00	710,800.00	0.00	
АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох	710,800.00	710,800.00	0.00	
УРСГАЛ ЗАРДАЛ	710,800.00	710,800.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	710,800.00	710,800.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	710,800.00	710,800.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	374,026,300.00	377,743,582.60	-3,717,282.60	
АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт,	374,026,300.00	377,743,582.60	-3,717,282.60	
УРСГАЛ ЗАРДАЛ	374,026,300.00	377,743,582.60	-3,717,282.60	100.99
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,026,300.00	377,743,582.60	-3,717,282.60	100.99
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	312,919,700.00	316,821,677.10	-3,901,977.10	101.25
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39115000	39115000	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	4088200	3963305.5	124,894.50	96.95
Нормативт зардал	7758700	7758700	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2323300	2323300	0.00	100.00
Томилолт, зочны зардал	196800	168000	28,800.00	85.37
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	1077900	1046900	31,000.00	97.12
Бараа үйлчилгээний бусад зардал	6546700	6546700	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	35813100	23642400.5	12,170,699.50	
АРГА ХЭМЖЭЭ 81835 Сургалтын хэвийн үйл	35813100	23642400.5	12,170,699.50	
УРСГАЛ ЗАРДАЛ	35813100	23642400.5	12,170,699.50	66.02
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35813100	23642400.5	12,170,699.50	66.02
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	23247200	17488056	5,759,144.00	75.23
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2905900	2905900	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	3192000	3248444.5	-56,444.50	101.77
Эд хогшил, урсгал засварын зардал	6468000		6,468,000.00	

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн 13646.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Шилэн дансны тухай” хуулийн дагуу мэдээлэх мэдээллээс 151 мэдээллээс 143 мэдээллийг байршуулсан, 6 мэдээллийг хугацаа хугацаа хоцроож байршуулсан, Үүнээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 161336.2 мянга, зарлагын 21066.2 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт-3

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа болоогүй	Хугацаа хоцроож байршуулсан	Мэдээллийг хугацаандаа байршуулаагүй	Үүнээс Хугацаа хоцроож байршуулсан							
								Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын		Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан өрт хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн туншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /мян.төг/		
								Тоо	Тоо				Тоо	Тоо	Тоо
1	Бүтэн жил	11	11	9	2										
2	Хагас жил	4	4	4		0									
3	Улирал бүр	1	4	3		0									
4	Сар бүр	3	36	32		0									
5	Тухай бүр	8	96	86		6	1	1			1	3	161,336.2	21,066.2	
Нийт		27	151	134	2	6	0	1	1	0	3	161,336.2	21,066.2		

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5630.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 3350.0 мянган төгрөгийг 3 төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2280.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	3350.0	3	3350.0			
Зөвлөмж	1	2280.0	1	2280.0			
Нийт дүн	4	5630.0	4	5630.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6496.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1603,3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4893,5 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ. /Хавсралт-1/

Залруулсан алдаа Байхгүй

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 6496.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1603,3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4893,5 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас 34 албан хаагчийг эмнэлгийн үзлэг шинжилгээнд хамруулахаар 1360.0 мянган төгрөгийг, Эрхлэгчийн тушаалаар сахилгын шийтгэл авсан 3 албан хаагчид 243.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3 дахь "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно." гэсэн заалттай нийцэхгүй, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоож 1603,3 мянган төгрөгийг төсөвт төлүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 4893,5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД **Байхгүй**

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 2700.0 мянган төгрөгөөр дрож, шуудан холбооны зардлаас 220.0 мянган төгрөгөөр санхүүгийн программын төлбөр төлж зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зөвшөөрөлгүй зориулалт бусаар зарцуулсан байх.

1.3. Өгсөн зөвлөмж: Нормын хувцас зөөлөн эдлэл зардал, шуудан холбооны зардлыг зориулалтын дагуу зарцуулж Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тухайн цэцэрлэгт НҮБ-ын эрүүл хооллолт идэвхтэй хөдөлгөөн төсөл хэрэгжүүлж 2020 оны төсөвт батлагдсан орон тооноос 9 дүгээр сараас эхлэн "Хоол зүйч"-ыг ажиллуулж 1973.5 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3. батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Зардал хэтрэх өр авлага үүсэх эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Орон тоо батлагдаагүй байхад илүү орон тоогоор ажиллуулж байгааг цаашид зогсоож, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт: Тайлант хугацаанд “Шилэн дансны тухай” хуулийн дагуу мэдээлэх мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хугацаа хоцроож байршуулсан, үүнээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 161336.2 мянга, зарлагын 21066.2 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

3.2.Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

3.3.Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын холбоотой мэдээллийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

3.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

Г.ГАНЧИМЭГ 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25



Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/62/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингийн зардлаас 34 албан хаагчийг эмнэлгийн үзлэг шинжилгээнд хамруулахаар 1360.0 мянган төгрөгийг, Эрхлэгчийн тушаалаар сахилгын шийтгэл авсан 3 албан хаагчид 243.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	1603.3	Төлбөрийн акт	Эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Мөнхзул, Г.Чулуунцэцэг
2	Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 2700.0 мянган төгрөгөөр дроз, шуудан холбооны зардлаас 220.0 мянган төгрөгөөр санхүүгийн программын төлбөр төлж зардлыг зориулалт бусаар зарцуулсан	2,920.0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Мөнхзул, Г.Чулуунцэцэг
3	Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу мэдээлэх мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хугацаа хоцроож байршуулсан, Үүнээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 161336.2 мянга, зарлагын 21066.2 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Мөнхзул, Г.Чулуунцэцэг
4	Тухайн цэцэрлэгт НҮБ-ын эрүүл хооллолт идэвхтэй хөдөлгөөн төсөл хэрэгжүүлж 2020 оны төсөвт батлагдсан орон тооноос 9 дүгээр сараас эхлэн "Хоол зүйч"-ыг ажиллуулж 1973.5 мянган төгрөгийн цалинг олгосон байна.	1,973.5	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, Нягтлан бодогч	Д.Мөнхзул, Г.Чулуунцэцэг
ДҮН		6496.8			

оОо